



Ханган нийлүүлэгчдэд зориулсан зөвлөмж

Хувилбарын дугаар №1
2013 оны 12 дугаар сар 12

www.ot.mn

Managed by

RioTinto





Гарчиг

Түгээмэл ашигладаг нэр томъёонууд:	2
Хавсралтууд:	2
1.0 Бараа худалдан авах захиалгын ерөнхий нөхцөл	3
1.1 Бараа худалдан авах ерөнхий нөхцөл:	3
1.2 Аюулгүй ажиллагаа	3
1.3 Бараа худалдан авах гэрээний тухай /PO/	3
1.4 Нийлүүлэх эцсийн хугацаа:	4
1.5 Сав баглаа боодолд тавигдах шаардлага:	4
1.6 Үнийн санал	4
1.7 Бараа хүлээлгэн өгөх	5
1.8 Төлбөрийн нөхцөл:	7
2.0 Ханган нийлүүлэгчээр бүртгүүлэх тухай	7
2.1 Ханган нийлүүлэгчийн нэгдсэн мэдээллийн бааз:	7
2.2 Байгууллагын худалдан авалтын дотоод систем	8



ТҮГЭЭМЭЛ АШИГЛАДАГ НЭР ТОМЬЁОНУУД:

1. Бараа худалдан авах ерөнхий нөхцөл /General terms and condition/
2. Аюулгүй ажиллагаа / Safety/
3. Хөдөлмөр хамгааллын хувцас-XXX /PPE – personal protection equipment/
4. Захиалгын дугаар /PR number/
5. Материал дугаар /Material number/Stock code /
6. Худалдан авах гэрээ /Purchasing order - PO/
7. Худалдан авах гэрээний дугаар /PO number/
8. “Бараа материалын хүлээн авалтын баримт” /Packing list/
9. Хор аюулын лавлах материал-ХАЛМ /Material Safety Data Sheet-MSDS/
10. Нэхэмжлэх / Invoice /
11. Үнийн санал /Quote/
12. Баглах, тэмдэглэгээ болон тээвэрлэлт хийх зааварчилгаа / Packing, Marking & Shipping Instructions /
13. Ханган нийлүүлэгчийн мэдээллийн сан /Supplier data base/
14. Байгууллагын худалдан авалтын дотоод бүртгэлийн систем /SAP system/

ХЭРЭГЦЭЭТЭЙ ХАВСРАЛТ ФАЙЛУУД:

1. Хавсралт 1: Гэрээний ерөнхий нөхцөл ба нэр томъёоны тайлбар
2. Хавсралт 2: Аюултай болон хорт бодист тавигдах шаардлага
3. Хавсралт 3: Худалдан авах гэрээний загвар
4. Хавсралт 4: Бараа бүтээгдэхүүний тэмдэглэгээ, баглаа боодлын зааварчилгаа
5. Хавсралт 5: Баглах, тэмдэглэгээ болон тээвэрлэлт хийх зааварчилгаа
6. Хавсралт 6: Үнийн саналын загвар
7. Хавсралт 7: Барааг агуулахад хүлээлгэж өгөх баримт
8. Хавсралт 8: Агуулахын цагийн хуваарь, холбоо барих утас
9. Хавсралт 9: Нэхэмжлэх бичих зөвлөмж
10. Хавсралт 10: Нэхэмжлэхний загвар
11. Хавсралт 11: Ханган нийлүүлэгчийн мэдээллийн санд бүртгүүлэх зөвлөмж
12. Хавсралт 12: Дотоод системд ханган нийлүүлэгчээр бүртгүүлэх маягт



1.0 БАРАА ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1 БАРАА ХУДАЛДАН АВАХ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ:

Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэгч болохын тулд юуны өмнө та “ Бараа худалдан авах ерөнхий нөхцөл” – тэй сайтар танилцаж, хүлээн зөвшөөрсөн байх шаардлагатайг анхаарна уу

Хавсралт №1 “ Бараа худалдан авах ерөнхий нөхцөл” –тэй танилцана уу

“ Бараа худалдан авах ерөнхий нөхцөл” –тэй танилцаж хүлээн зөвшөөрсөн

- ✓ Төлбөрийн нөхцөл: Бараа нийлүүлснээс хойш 30 хоногийн дараа төлбөрийг төлнө
- ✓ Барааг Оюу Толгой ХХК-ийн агуулахад хүргэж өгнө

Тийм

Үгүй

1.2 АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагааны талаарх бидний алсын хараа нь: “Өдөр бүр хүн болгон ажлаасаа эрүүл, аюулгүй эргэн ирэхүйц осол аваар, өвчлөлгүй ажлын байрыг хамтдаа бий болгох” явдал билээ.

Аюулгүй ажиллагааны хүрээнд ханган нийлүүлэгчдээс дараах зүйлсийг нэн тэргүүнд шаарддаг.

1. Бид ханган нийлүүлэгчдээ мөн адил ЭМААБО-ны (Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин) тодорхой бодлого, журам, аюул эрсдлийн үнэлгээний тогтолцоотой байхыг шаарддаг.
2. Барааг агуулахад хүргэж өгөхдөө ханган нийлүүлэгч эсвэл түүний төлөөлөгч мөн болохыг нотлох бичиг баримт болон хамгаалалтын хатуу малгай, битүү гутал зэрэг хөдөлмөр хамгааллын хувцастай ирэхийг шаарддаг.
3. Таны нийлүүлэх гэж буй бараа нь химийн бодис болон аюултай ачаа ангилалд багтдаг бол хор аюулын лавлах материал буюу ХАЛМ /MSDS/ -ыг Монгол ба Англи хоёр хэл дээр дагалдуулж авчирч өгөхийг шаарддаг.

Хавсралт №2 Аюултай болон хорт бодист тавигдах шаардлага

1.3 БАРАА ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ТУХАЙ /РО/

Энэ нь танай компанитай байгуулж байгаа бараа худалдан авах гэрээ юм.



Худалдан авалтын гэрээний тайлбар:

Хавсралт №3 “Худалдан авах гэрээний загвар”-ыг үзнэ үү

1.4 Нийлүүлэх эцсийн хугацаа:

Худалдан авалтын захиалгын хувьд нийлүүлэх эцсийн хугацаа маш чухал үзүүлэлт бөгөөд үүн дээр үндэслээд тухайн бараа, үйлчилгээг цаашид ашиглах дараа дараачийн төлөвлөгөө хийгдэж, ажил хэвийн явагдах нэг үндэс суурь болж байдаг. Иймд бид хугацаандаа бараа үйлчилгээгээ нийлүүлэх тал дээр ханган нийлүүлэгчээс хариуцлагатай хандахыг шаарддаг. Энэ нь мөн урт хугацааны хамтын ажиллагаанд нэг чухал үзүүлэлт болдог.

Хугацаандаа нийлүүлээгүй тохиолдолд алданги тооцдог.

1.5 САВ БАГЛАА БООДОЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Сав баглаа боодол нь барааг **тээвэрлэх, хадгалах** явцад тухайн барааны талаар мэдээллийг авах, чанарыг хамгаалах, барааг бүртгэж тоолох, өрөх хураах ажлыг эмх цэгцтэй хийх зэрэг ач холбогдолтой. Та Оюу Толгой ХХК-ийн захиалсан барааг агуулахад хүргэж өгөхдөө дараах зааварчилгаатай танилцсан байх шаардлагатай.

Хавсралт №4 Бараа бүтээгдэхүүний тэмдэглэгээ, баглаа боодлын зааварчилгааг үзнэ үү
Хавсралт №5 Баглах, тэмдэглэгээ болон тээвэрлэлт хийх зааварчилгааг үзнэ үү

Та захиалсан бараа бүтээгдэхүүнийг агуулахад хүргэж өгөхдөө сав баглаа боодлын гадна талд дараах мэдээллүүдийг ил харагдахуйц байрлуулсан байх шаардлагатай.

- a) Ханган нийлүүлэгчийн нэр
- b) Захиалгын дугаар буюу PR дугаар
- c) Оюу Толгой ХХК-ийн материал дугаар
- d) Барааны нэр
- e) Барааны тайлбар /хэмжээ, тоо ширхэг, жин/
- f) Гэрээний дугаар
- g) Хүлээн авах агуулахын хаяг /Улаанбаатар агуулах эсвэл Оюу Толгой төслийн талбар дээрх агуулах гэх мэт/
- h) Хүлээн авагчийн нэр /Захиалсан хэлтсийн нэр/

1.6 ҮНИЙН САНАЛ

Оюу Толгой ХХК-ийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бараа, үйлчилгээ нийлүүлдэг боломжит ханган нийлүүлэгчдээс үнийн санал авч өрсөлдөөнт сонгон шалгаруулалтыг хийдэг.

Үнийн саналд доор дурдсан мэдээллүүдийг багтаасан байвал зохино.

1. Компаний нэр



2. Үнийн саналын хүчинтэй хугацаа
3. Бараа үйлчилгээний нэр/с/
4. Нэг бүрийн үнэ, тоо ширхэг, нийт үнэ, НӨТ багтсан эсэх
5. Барааны товч тайлбар /өнгө, материал, жин, хэмжээ гэх мэт. шаардлагатай бол гэрэл зураг оруулах/
6. Дагалдах материалууд /Чанарын гэрчилгээ, гарын авлага, баталгааны хуудас, Химийн бодис бол ХАЛМ/
7. Тээвэр болон сав баглаа боодлын үнэ багтсан эсэх
8. Холбоо барих утас, хаяг
9. Барааг хүргэж өгөх эцсийн хугацаа

Хавсралт №6 “Үнийн саналын загвар”-ыг үзнэ үү

1.7 БАРАА ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

Та “Бараа худалдан авах гэрээ” –нд заасан агуулахад бараа үйлчилгээг хүргэж өгөх шаардлагатай.

Иймд та үнийн саналдаа, хүргэж өгөх агуулах хүртэлх тээврийн зардал, ачаа гэмтэхээс сэргийлсэн сав баглаа боодлын зардлыг оруулсан үнийг оруулж өгөх нь зүйтэй юм.

Оюу Толгой ХХК нь дотоодоос бараа ханган нийлүүлэгч нарт Улаанбаатар дахь агуулах хүртэл эсвэл Өмнөговь аймаг, Оюу Толгой Төслийн талбар дахь агуулахад хүргэх нөхцлийг тавьдаг.

Гадаадаас бараа нийлүүлэх ханган нийлүүлэгч нарын хувьд гэрээнд заасан нөхцлөөр барааг хүлээн авдаг.

Барааг агуулахад хүргэж өгөхдөө Оюу Толгой компаний ашигладаг Packing list буюу “Бараа материал хүлээн авалтын баримт”-ыг бөглөн, хүлээн авсан гэсэн гарын үсгийг агуулахын ажилтнаар зуруулж авна.

Анхаарах зүйлс:

Оюу Толгой компани, агуулахын эмх цэгцтэй байдлыг хангах үүднээс бараа хүлээн авахдаа дараах тохируулах системийг ашигладаг.

Оюу Толгой компаний хэрэгжүүлдэг 3 зарчим – Тохируулах систем

1. ОТ Захиалгын хуудас
2. Нийлүүлэгчийн Баглаа боодлын жагсаалт
3. Бараа материал

Бараа материал тохируулах шалгуур

- ✓ Тоо хэмжээ



- ✓ Тайлбар
- ✓ Материал дугаар
- ✓ Үзүүлэлт
- ✓ Хэмжих нэгж

Хавсралт №7 Барааг агуулахад хүлээлгэж өгөх баримтыг үзнэ үү
Хавсралт №8 Улаанбаатар Агуулахын ажиллах цагийн хуваарь –ийг үзнэ үү

Яаралтай ачаа:

Зарим тохиолдолд тухайн ачааг онгоцоор Оюу Толгой уурхайн талбар луу тээвэрлэх шаардлага гардаг.

Хэрвээ Оюу Толгой компаний хангамжийн ажилтан танд онгоцоор барааг илгээх хүсэлт тавьсан тохиолдолд дараах зөвлөмжийг мөрдөж ажиллана уу

1. Тухайн ачааг онгоцоор илгээх зөвшөөрлийг танд хүсэлт тавьсан Оюу Толгой компаний ажилтан өөрөө авсан байх шаардлагатай.
2. Онгоцоор илгээх ачааг СХД, 20-р хороо, Сонсголонгийн гудамжинд байрлах Оюу Толгой компаний Улаанбаатар агуулахад хүргэж өгнө.
3. Илгээж буй ачаан дээр хүлээн авах хүний нэр, утасны дугаар, хэлтэс, компаний нэрийг тод гаргацтай бичиж наасан байх ба найдвартай сав баглаа боодолтой байна. Онгоцны буудал дээр ачаа тээш нэг бүрийг нислэгийн аюулгүй байдлын үзлэгээр дахин шалгагдах болно.
4. Ачаа илгээгч нь Агуулахын ажилтанд ачаа тээшний талаар үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй. Буруу мэдээлэл өгснөөр тухайн нислэгт аюултай ачаа тээвэрлэгдэх магадлалтай ба улмаар нислэгийн аюулгүй ажиллагаа, зорчигчдын аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүйг анхаарах хэрэгтэй.
5. Нэг баглаа боодол ачааны жин нь 35 кг-с илүүгүй байх ёстой. Нэг баглаа боодол ачааны зөвшөөрөгдөх хэмжээг дараах хүснэгтээс харна уу.

Албаны ачааны хязгаарлалт: Улаанбаатар – ОТ сайт Захиалгат нислэг		
Нислэгийн төрөл	Аэро Монголиа Онгоцны төрөл: Фокер 50	Изинис Эйрвэйз Онгоцны төрөл: Q-400
Баглаа боодлын хэмжээ	Нэг баглаа боодол ачааны өргөн нь 0,4м, урт нь 0,3м, өндөр нь 1,7м-с хэтрэхгүй	Нэг баглаа боодол ачааны өргөн нь 1,22м, урт нь 1,4м, өндөр нь 1,52м-с хэтрэхгүй
Баглаа боодлын жин	35 кг-с хэтрэхгүй	35 кг-с хэтрэхгүй



6. Албаны зориулалтаар ачаа илгээхдээ агаараар тээвэрлэх хориотой эд зүйлс (Агаараар тээвэрлэх хориотой эд зүйлс), аюултай эд зүйлс (Аюултай ачааны заавар) агуулсан ачаа илгээхийг хатуу хориглоно.
7. Илгээгч, хүлээн авагчтай холбоо барих мэдээллийг (нэр, хаяг, утасны дугаар) ачаа хүлээн авах хуудсанд бүрэн бүртгэж тэмдэглэнэ.
8. Ачаа ОТ сайт дахь Агуулахад хүргэгдэх ба ачаан дээрх нэрийн шошгон дээр бичигдсэн хаягаар хүлээн авагч руу илгээнэ.

1.8 ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ:

Оюу Толгой ХХК –ийн төлбөрийн нөхцлийн дагуу нэхэмжлэх ирүүлсэн өдрөөс 30 хоногийн дотор төлбөрийг төлдөг нөхцөлтэй.

Өмнөговийн ханган нийлүүлэгчдийг дэмжих бодлогын дагуу Өмнөговь аймагт бүртгэлтэй ААН-ийн төлбөрийг нэхэмжлэх ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн төлбөрийг төлдөг.

Нэхэмжлэх:

Нэхэмжлэх нь ачуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний хөлсийг нэхэмжлэх үндсэн баримт болох бөгөөд бүх төрлийн тооцооны дансдыг хөтлөх анхан шатны баримт болно. Нэхэмжлэхийг тоон дэс дарааллаар дугаарлана. НӨАТ гэсэн мөрөнд нийлүүлсэн бараа, үзүүлсэн ажил үйлчилгээнд ногдох Нэмэгдсэн өртгийн албан татварыг бичнэ. Хэсгийн дүнг тухайн үед мөрдөж буй НӨАТ-ийн хувиар үржүүлж НӨАТ-ийн дүнг тооцоолно. Нэхэмжлэгч байгууллагын дарга, нягтлан бодогч гарын үсэг зурж, тамга дарна.

Хавсралт №9 Нэхэмжлэх бичих зөвлөмжтэй танилцана уу

Хавсралт №10 Нэхэмжлэхний загвар

2.0 ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧЭЭР БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ

Оюу Толгой ХХК-ийн Хангамжийн хэлтэс нь доорх хоёр төрлийн системийг өдөр тутмын ажилдаа ашиглаж байна.

2.1 ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН НЭГДСЭН МЭДЭЭЛЛИЙН БААЗ:

Энэ мэдээллийн баазад ханган нийлүүлэгч болохыг хүссэн бүх байгууллага, хувь хүмүүс өөрсдөө нэвтрэн орж, ханган нийлүүлэгчээр чөлөөтэй бүртгүүлж болно.

Оюу Толгой ХХК-ийн хангамжийн ажилтнууд энэхүү мэдээллийн баазаас боломжит ханган нийлүүлэгчийг хайж, холбоо тогтоон, гэрээ хэрэгжүүлэх чадварт нь үнэлгээ хийж өөрөөр хэлбэл тухайн ханган нийлүүлэгчийг илүү таньж мэдэх ажил энэ системээр дамжуулан хийгдэж байдаг.

Энэ системийн зорилго: Оюу Толгой ХХК нь Ханган нийлүүлэгчийн үнэлгээ, менежментийн системийг бий болгож байгаа бөгөөд энэ нь одоогийн болон ирээдүйн боломжит ханган нийлүүлэгчдийн мэдээллийг цуглуулж, хадгалах цахим систем юм.



Уг системээр үүсгэсэн Ханган нийлүүлэгчийн нэгдсэн мэдээллийн санг бид худалдан авалтын үйл ажиллагаанд оролцох боломжит ханган нийлүүлэгчдийг сонгон, өрсөлдөөнт тендер шалгаруулалтанд урьж оролцуулахад ашиглана.

Оюу Толгой ХХК-ийн ханган нийлүүлэгч болох эхний алхам нь энэ мэдээллийн санд бүртгүүлэхээс эхэлнэ.

Доорх цахим хаягаар орж ханган нийлүүлэгчээр бүртгүүлнэ үү

<http://ot.mn/mn/procurement/how-to-become-a-supplier>

Хавсралт 11: Ханган нийлүүлэгчийн мэдээллийн санд бүртгүүлэх зөвлөмжийг www.ot.mn вэб сайтын Худалдан авалт гэсэн хэсгээс татаж авна уу

2.2 БАЙГУУЛЛАГЫН ХУДАЛДАН АВАЛТЫН ДОТООД СИСТЕМ /SAP/

Энэхүү систем нь Оюу Толгой ХХК-ийн дотоод систем бөгөөд хангамжийн ажилтны хүсэлтээр энэхүү системд бүртгүүлдэг.

Бүртгүүлэхэд бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтууд:

ААН, байгууллага:

- a) ААН-ийн гэрчилгээний хуулбар
- b) НӨТ төлөгчийн гэрчилгээ /Хэрвээ НӨТ төлөгч бол/
- c) Банкны тодорхойлолт /Данс эзэмшдэг нь үнэн гэсэн утга бүхий/
- d) Тухайн банкинд данс эзэмшдэг нь үнэн гэсэн ханган нийлүүлэгчийн албан бичиг
- e) Шинэ ханган нийлүүлэгчийн бүртгэлийн маягт /Оюу Толгой ХХК-ийн ажилтан өөрөө бөглөнө/

Хувь хүн:

- a) Иргэний үнэмлэхний хуулбар
- b) ХХОАТ-ын дэвтэр /татвар төлөгчийн орлогын бүртгэлийн дэвтэр/
- c) Банкны тодорхойлолт /Данс эзэмшдэг нь үнэн гэсэн утга бүхий/
- d) Тухайн банкинд данс эзэмшдэг нь үнэн гэсэн ханган нийлүүлэгчийн бичиг
- e) Шинэ ханган нийлүүлэгчийн бүртгэлийн маягт /Оюу Толгой ХХК-ийн ажилтан өөрөө бөглөнө/

Хавсралт №12 Дотоод системд, ханган нийлүүлэгчээр бүртгүүлэх маягтыг үзнэ үү

